



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 84,5 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4, 8.5, 21, 48.1, 49 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй, нээлттэй тендер зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглээгүй, 409.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолыг зөрчин дээд байгууллагын гадаад томилолтыг 40.2 сая төгрөгөөр санхүүжүүлж үргүй зардал гаргасан зэрэг нийт 534.0 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал А.Бямбадоржид дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

2.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.3. Байгууллагад хөтлөгдөж буй баримт бичиг, гэрээ, эрхийн актуудыг архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн журам зааврын дагуу бүрдүүлэх, хадгалах;

2.4. Удирдах дээд байгууллагын гадаад томилолт болон бусад төсөл арга хэмжээг санхүүжүүлэхийг Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолын дагуу таслан зогсоох;

2.5. Дээд байгууллагаас гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, биелэлтийг хугацаанд нь ирүүлэх.

2.6. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

0000495

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД